



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 8771

Арвайхээр

Г Нэмэлт ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулах тухай

Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2, 35 дугаар зүйлийн 35.1.2 дахь заалт болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хархорин суманд баригдаж буй 75 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Хангай энержи” ХХК-ийн гүйцэтгэж буй ажлын тоо хэмжээнд тусгагдаагүй гадна талбайн тохижилтын ажил, явган хүний зам, ногоон байгууламж, бетон суурьтай төмөр хашаа барих ажлыг нэмэлт ажил гүйцэтгүүлэх гэрээгээр гүйцэтгүүлсүгэй.
2. Нэмэлт гэрээ байгуулж гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-д даалгасугай.
3. Нэмэлт ажилд шаардагдах 44.058.042 (дөчин дөрвөн сая тавин найман мянга дөчин хоёр) төгрөгийг Сангийн яаманд уламжлан тендерийн үнийн зөрүү зардлаас шийдвэрлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД



011101475

D:My Doc. Zahiramj. Zasag darga